# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
# “ АМИЯА ББСБ” ХХК-ИЙН
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ТАНАА

## Санхүүгийн тайлангийн Аудитын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тодруулгаас бүрдсэн “Амияа ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Амияа ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд, Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуух үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### Компанийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага компанийн санхүүгийн тайланг гаргах болон үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах чадамжтай байх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан гэсэн ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Огноо: 2025 оны 02 дугаар сарын 04 өдөр

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 хороо, 6 хороолол, 65 байр, 1 тоот,
Утас: 70130460, 99109702
И мэйл хаяг: auditulziit@gmail.com

**"Амияа ББСБ" ХХК** **Регистрийн дугаар: 5704987**

## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ

Санхүүгийн байдлын тайлан 2025.02.04

**Аудитлагдсан дүн /төгрөгөөр/**

| | 2023 оны 12 сарын 31 | 2024 оны 12 сарын 31 |
|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 100,186,747 | 228,510,557 |
| Зээл /цэвэр/ | 4,614,019,472 | 4,822,955,099 |
| Бусад авлага | 4,600,000 | 100,000 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 128,304,680 | 79,776,710 |
| Бусад хөрөнгө | 92,124,594 | 41,320,686 |
| Үндсэн хөрөнгө | 243,146,858 | 93,109,745 |
| Биет бус хөрөнгө | - | - |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,182,382,351** | **5,265,772,797** |
| Богино хугацаат өр төлбөр | 1 | - |
| Урт хугацаат өр төлбөр | | |
| Дүрмийн сан | **2,500,000,000** | **2,500,000,000** |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Хуримтлагдсан ашиг | **2,682,382,350** | **2,765,772,797** |
| Нийт эздийн өмч | 5,182,382,350 | 5,265,772,797 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **5,182,382,351** | **5,265,772,797** |

Орлого үр дүнгийн тайлан

| | | |
|---|---|---|
| Хүүгийн орлого | 1,210,728,924 | 1,048,490,483 |
| **Цэвэр хүүгийн орлого** | **1,210,728,924** | **1,048,490,483** |
| Хүүгийн бус орлого | 235,423,919 | 314,105,165 |
| Хүүгийн бус зардал | 306,314,209 | 304,186,097 |
| Болзошгүй эрсдлийн зардал | 136,891,053 | 684,879,827 |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **1,002,947,581** | **(674,960,759)** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | - | |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | | 12,453,980 |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг** | **1,002,947,581** | **361,075,744** |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал** | **1,002,947,581** | **361,075,744** |
| Орлогын татварын зардал | | 5,185,297 |
| **Цэвэр ашиг /алдагдал/** | **1,002,947,581** | **355,890,447** |

**Мөнгөн гүйлгээний тайлан**

| | | |
|---|---|---|
| Мөнгөн орлогын дүн | 6,836,497,825 | 7,067,839,658 |
| Мөнгөн зарлагын дүн | 7,046,438,427 | 6,939,515,848 |
| Цэвэр мөнгөн гүйлгээ | 209,940,602 | 128,323,810 |
| **Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл** | **100,186,747** | **100,186,747** |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **310,127,349** | **228,510,557** |

Аудитор Ч.Эрдэнэжав



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК